



СУХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 01

Баруун-Урт сум

Засаг даргын зөвлөлийн хурал 2022 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн 16 цаг 00 минутад аймгийн Засаг даргын өрөөнд хурлын ирц 84,6 хувьтай эхлэв.

Хуралдаанд дараах зөвлөлийн хурлын гишүүд оролцов.

М.Идэрбат	- Аймгийн Засаг дарга
Г.Мөнхзаяа	- Аймгийн Засаг даргын орлогч
Д.Шижирбаатар	- Аймгийн Засаг даргын орлогч
П.Мөнжаргал	- Тамгын газрын дарга
Д.Болд-Эрдэнэ	- Засаг даргын зөвлөх
Э.Энхжаргал	- Засаг даргын зөвлөх
Б.Амарзаяа	- Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга
Д.Ариунжаргал	- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Д.Баасандорж	- Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хэлтсийн дарга
Ө.Баясгалан	- Цэргийн штабын даргын түр үүрэг гүйцэтгэгч
Г.Ганзориг	- Хууль эрх зүйн хэлтсийн даргыг түр орлон гүйцэтгэгч

Зөвлөлийн хурлын гишүүн О.Батзаяа, С.Сүхбаатар нар нь утас нь холбогдохгүй тул хуралд оролцох боломжгүй. Хурлын ирц 84,6 хувьтай.

ХЭЛЭЛЦСЭН нь:

Аймгийн Засаг дарга М.Идэрбат:

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдрийн засаг даргын зөвлөлийн хурлаар 2021 оны хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн тухай танилцуулна.

АСУУДАЛ ТАНИЛЦУУЛСАН НЬ:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн талаар Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Хурцбаяр танилцуулга хийв.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журамд заасны дагуу Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхий сайдын захирамж Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цахим мэдээллийн систем unelgee.gov.mn-д байршуулсан.

2021 оны жилийн эцсийн байдлаар МУ-ын хууль 9, УИХ-ын тогтоол 1, УИХ-ын байнгын хорооны тогтоол 3, Ерөнхийлөгчийн зарлиг 4, УАБЗ-ийн зөвлөмж-4, УАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл-1, ЗГ-ын тогтоол 59, Ерөнхий сайдын захирамж 1, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл 24, ЗГ-ын албан даалгавар 4 нийт 109 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 206 заалтыг хяналтад авч **95,92** хувийн биелэлттэй дүгнэсэн. Үүнээс: 100 хувийн биелэлттэй буюу бүрэн хэрэгжсэн 182 заалт, 70 хувь буюу хэрэгжих шатанд 21 заалт, 30 хувь буюу хэрэгжилт хангалтгүй 3 заалт тус тус байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг шийдвэрээр аяч үзээл:

Шийдвэрийн нэр	Шийдвэрийн тоо	Хяналтад авсан нийт заалтын тоо	Өөрийн үнэлгээ	Бүрэн хэрэгжсэн 100%	Хэрэгжих шатанд 70%	Хэрэгжилт хангалтгүй 30%	Хэрэгжээгүй 0%	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй хугацаа болоогүй чанзаж боловсрухийн
Жилийн эцсийн үнэлгээ	109	206	95.92	182	21	3	0	0
МУ-ын хууль	9	28	100	28	0	0	0	0
УИХ-ын тогтоол	1	1	100	1	0	0	0	0
УИХ-ын байнгын хорооны тогтоол	3	4	100	4	0	0	0	0
Ерөнхийлөгчийн зарлиг	4	10	88	6	4	0	0	0
УАБЗ-ийн зөвлөмж	4	10	82	4	6	0	0	0
УАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	1	5	86	4	0	1	0	0
ЗГ-ын тогтоол	59	92	96.2	83	7	2	0	0
Ерөнхий сайдын захирамж	1	1	100	1	0	0	0	0
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	24	37	96.8	33	4	0	0	0
ЗГ-ын албан даалгавар	3	18	95.8	18	0	0	0	0

Хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувьтай шийдвэрүүд:

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай 2010-03-18 Дугаар 2010_10/03
Заалт: 5. Орон сууц, олон нийт, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын барилга байгууламжуудын газар хөдлөлтийг тэсвэрлэх байдлын үзлэг, шалгалтыг хийх, бүх барилгыг паспортжуулан ашиглалтын хэвийн нөхцөлөөр хангулж, мэдээллийн сан байгуулах, бүсийн тулгуур төв, аймаг, нийслэлийн газар хөдлөлтийн эрдэлийн үнэлгээг хийх, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, төлөвлөлтийг

боловсронгуй болгох чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцаан хамтарч ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх, (Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, аймаг, нийслэлийн Засаг дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар)

Хэрэгжилт Засаг даргын тамгын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагатай хамтран 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр орон тооны бус зөвлөлийг байгуулан 16 аж ахуйн нэгжийн барилга байгууламжид паспортжуулалтын ажил хийгдээд байна. Мөн газар хөдлөлтийн үед нурах эрсдэл бүхий 63 барилга байгууламжийн судалгааг Газрын харилцаа хот байгуулалтын газар, мэргэжлийн хяналтын газартай хамтран гаргасан.

Нийтийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-12-25
Дугаар 2019_474

Заалт: 4.. Инженерийн дэд бүтэцтэй болон төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломжтой хот, суурин газарт унд, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар шинээр худаг гаргаж, ус ашиглах зөвшөөрөл, дүгнэлт олгохыг хязгаарлах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, аймаг, нийслэлийн Засаг дарга наарт үүрэг болгосугай.

2022 онд ажлын хэсэг байгуулагдахаар төлөөвлөн ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай 2020-04-22 Дугаар 2020_144

Заалт: 1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлагатай наарт үүрэг болгосугай.

2020 оны байдлаар хэмжүүрээр тооцоо хийдэг 9-н аж ахуй нэгж байгууллага байна. Үүнээс төсөвт байгууллага 1, аж ахуй нэгж 8 байна. Цаашид тоолуур сууринтуулж болох төсвийн 40 албан байгууллага байна. Ковид-19 цар тахлын улмаас хийгдсэн ажил, арга хэмжээ байхгүй.

Хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувьтай байгаа 3 заалтыг танилцууллаа. Үүнд УАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл 1, ЗГТ-2 байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар МУ-ын хууль 9 шийдвэр 28 заалт 100 хувьтай, УИХ-ын тогтоол 1 шийдвэр 1 заалт 100 хувьтай, УИХ-ын байнгын хорооны тогтоол 3 шийдвэр 4 заалт 100 хувьтай, Ерөнхийлөгчийн зарлиг 4 шийдвэр 10 заалт 88 хувьтай, УАБЗ-ийн зөвлөмж 4 шийдвэр 10 заалт 82,0 хувьтай, УАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл 1 шийдвэр 5 заалт 86 хувьтай, ЗГ-ын тогтоол 59 шийдвэр 92 заалт 96,2 хувьтай, Ерөнхий сайдын захирамж 1 шийдвэр 1 заалт 100 хувьтай, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл 24 шийдвэр 37 заалт 96,8 хувьтай, ЗГ-ын албан даалгавар 4 шийдвэр 18 заалт 95,8 нийт 109 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 206 заалтыг хяналтад авч **95,92** хувийн биелэлттэй байна.

Тайланг журмын дагуу Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, холбогдох хэлтсүүдээс биелэлтийг авч нэгтгэн, Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст ирүүлдэг бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд тайлагнант товч болсон боловч нийтлэг дутагдлууд байгааг хэлэх нь зүйтэй байна.

- ✓ Тайлан хугацаандаа ирэхгүй байх. (Аймгийн Засаг даргын 2021 оны А/343 дугаар захирамжаар баталсан журмын дагуу 2020.12.25 гэхэд Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст ирүүлсэн байх)
- ✓ салбарын тоо баримтыг бодитой тусгаагүй, зөрүүтэй тайлагнах
- ✓ өмнөх оны суурь түвшин, хүрэх түвшинтэй харьцуулахгүй,
- ✓ Хэт товч, тайлагнант тодорхойгүй
- ✓ ажлын үр дүн, үр нөлөөг тооцохгүй зөвхөн үйл ажиллагаа тайлагнаж байгаагаас тайланг дахин дахин буцааж, асууж тодруулах зэргээр хугацаа алдах зэрэг нийтлэг дутагдлууд байна.

Иймээс цаашид Тайланг гаргахдаа зөвхөн үйл ажиллагаа тайлагнах биш хийсэн ажлаа бүрэн тайлагнаж салбарын гол тоо баримтыг тайланд тусгаж, өөрсдийн хийсэн ажлын үр дүн, үр нөлөөг тооцож тайлагнаж хэвшиг шаардлагатай байна.

Г.Мөнхзаяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн хяналт-шинжилгээ хийсэн тухай тайланг сонслоо.

Монгол Улсын Засгийн газраас 2020 онд батлагдсан журмын дагуу үнэлэгдэж байна уу. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын үнэлгээ манай үнэлгээ нэг журмын дагуу үнэлэгдэх үү. Өнгөрсөн жилийн үнэлгээний зөрүү ямар байсан бэ?

Т.Хурцбаяр: 2020 оны Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу үнэлгээ хийгдсэн учир зөрүүгүй болно. 2019, 2020 оны жилийн эцсийн үнэлгээг харьцуулж үзсэн 2019 онд -1,92%, 2020 онд -1,16%-ийн бууралттай үнэлэгдсэн. 2019, 2020 оны үнэлгээ хооронд -0,76 хувиар буурсан нь үнэлгээний зөрүү багасаж зэрэг үзүүлэлттэй байна.

Э.Энхжаргал: Тайлан гаргахтай холбоотой нийтлэг дутагдлуудыг хэлж байна. Манай хэлтэс, мэргэжилтнүүд алдаа дутагдлыг арилгах, цаашлаад сумдад зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллах хэрэгтэй байна.

Д.Баасандорж: Манай хэлтсээс жил бүр тайлантай холбоотой алдаа дутагдлыг хэлдэг. Хэлтсийн дарга нар гарч байгаа тайланг маш сайн хянадаг баймаар байна. Зарим мэргэжилтнүүд салбарын тайланг аваад хянадаггүй, зүгээр л дамжуулаад өгдөг, салбартаа хийгдсэн томоохон ажил, арга хэмжээг орхигдуулдаг. Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн хувьд ирсэн тайлан мэдээг хянаад, алдаа дутагдлыг нэг бүрчлэн засаж байж зөвлөлийн хуралд танилцуулж байна. Э.Энхжаргал даргын саналыг хүлээж авлаа.

Б.Амарзаяа: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Үнэлгээ багатай байгаа заалтуудыг дахин нягталж үзээрэй. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт 95,92 хувьтай үнэлэгдсэн байна. Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст хэлэхэд хэн алдаа дутагдал удаа дараа гаргаад байна, хэн тайлан мэдээ хугацаа хожимдуулж байгаа талаар мэдээлэл өгч баймаар байна. Удаа дараа алдаа, дутагдал гаргаад байгаа зарим албан хаагчдад арга хэмжээ авах, цаашлаад ЗДТГ-аас гарч байгаа тайлан мэдээнүүд улам чанартай болж, тоо мэдээлэл үнэн бодит, үр дунд суурилсан тайланг хүргүүлэхийг холбогдох хэлтэс, мэргэжилтнүүдэд сануулъя.

М.Идэрбат: Зөвлөлийн гишүүдэд өөр санал хүсэлт, тодруулах зүйл байна уу. Бүгд санал нэгтэй дэмжих үү.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Зөвлөлийн гишүүд санал нэгтэй дэмжлээ. Тайланг заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлэхийг Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст үүрэг болгов.

Хуралдаан 2022 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн 17:30 минутад өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН
ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.АМАРЗАЯА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ЗАСАГ ДАРГЫН ТУСЛАХ

Д.СУМЬЯА